МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 03 сарын 19 өдөр Дугаар А-93 Улаанбаатар хот

2014 оны төсвийн төлөвлөгөө батлах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 273 дугаар тогтоолоор батлагдсан "Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус удирдах зөвлөлийн ажиллах журам"-ын 3.1, 3.5 дахь заалт, Цэвэр агаарын сангийн Удирдах Зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/14 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тусгай сан-Цэвэр агаарын сангийн 2014 онд санхүүжүүлэх үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөөг 1 дүгээр, Цэвэр агаарын сангийн дотоод зардлын төсвийг 2 дугаар, Цэвэр агаарын сангийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай.

2. Цэвэр агаарын сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавихыг тус сангийн гүйцэтгэх захирал /Д.Баасан/-д даалгасугай.

САЙД С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2014 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн
А-93 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

## ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/сая төгрөгөөр /

| № | Арга хэмжээ | 2013 оноос үргэлжлэн хэрэгжих төсөл арга хэмжээ | Захиалагч | 2014 оны төсвийн санал | 2014 оны төсвийн хуваарь | Тайлбар | Үндэслэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гэр хорооллын айл өрхийг сайжруулсан коксон шахмал түлшээр хангах зорилгоор нөөц бүрдүүлэх, түүнийг санхүүжүүлэх /2014-2015 онуудад/ татаас | | НЗДТГ | 5239.9 | 5239.9 | Баялаг Эрдэнэ цом ХХК, Шарын гол энерго ХХК 5000 тн түлш (1тн = 170000₮) нийлүүлэхээр 850.0 сая төгрөгний гэрээ хийгдсэн.<br>Мөн 2014 онд түлшинд 5889.9 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $12^{1}$ -р зүйлийн $12^{1}.2.2$ дахь заалт, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2014 оны 02 дугаар сарын 5-ны 01 дүгээр тогтоолын 2 дахь заалт |
| 2 | Гэр хорооллын айл өрхийг боловсруулсан үртсэн шахмал түлшээр хангах зорилгоор нөөц бүрдүүлэх, түүнийг санхүүжүүлэх / 2014-2015 онуудад/ - татаас | | НЗДТГ | 44.9 | 44.9 | ҮШТҮ 2013 оны 8-р сарын 13-наас 2014 оны 3 сарын 31-нийг хүртэл 2000 тн үртсэн шахмал түлш нийлүүлэхээр гэрээ байгуулсан. 2013 онд 1250 тн түлш нийлүүлэхээс 593.85 тн түлш нийлүүлсэн. 2014 он гараад 2 сарын 14-ний байдлаар НАЧА-нд 44.86 сая төгрөгийн 299.075 тн түлш нийлүүлсэн. | |
| 3 | Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих | | АББҮХ | 1500.0 | 1500.0 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Гэр хорооллын айлуудыг сайжруулсан зуухаар хангахад олгох татаас /2014-2015 онуудад/ - татаас | 3601.6 | НЗДТГ | 4302.9 | 7904.5 | Хүрд ХК усан халаалттай сайжруулсан зуух 6248 ш нийлүүлэхээс 4262 зуухны 1.3 тэрбум төгрөг санхүүжүүжигдсэн, 2014 онд 1986 ш зуух нийлүүлэх буюу 605.6 сая төгрөг тусгагдсан. Роял Өүшн ХХК-ний 16500 зуух нийлүүлсэн, 2014 онд 373 зуухны 130.4 сая төгрөг тусгагдсан. Дэлхийн банкны төслөөр 45000 зуух нийлүүлэхээс 2013 онд 11424 зуух нийлүүлсэн, үлдэгдэл 13402 болон 2014 онд 20174 -ийг нэмж нийтдээ 33576 зуух нийлүүлэхээр тооцогдсон. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $12^{1}$-р зүйлийн $12^{1}.2.2$ дахь заалт, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2013 оны 08-р сарын 19-ний өдрийн 13/30 дугаар тогтоол |
| 5 | Түлш нөөцлөх агуулах түрээслэх зардал /2014-2015 онуудад/ - татаас | | | 8.2 | 8.2 | 2013 оны гэрээ дүгнэсэн актаар 2014 оны 1-р сарын 27 хүртэл түлш хадгалсан 3 агуулахын төлбөр | |
| 6 | Түлш тээвэрлэх зардал /2014-2015 онуудад/ - татаас | | АББҮХ, НАЧА | 110.9 | 110.9 | Биомонголиа ХХК-тай гэрээ 1тн түлшийг 15545 төгрөгөөр нийт 2500 тн түлш тээвэрлүүлэхээр гэрээ байгуулсан. Мөн Эм Жи Эл Эс Би Ди ХХК 1н түлшийг 14410 төгрөгөөр ачиж буулгах, тээвэрлэхээр тооцогдсон | АББҮХ-ны 2011 оны 11/06 дугаар тогтоолын 5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2011 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 131 дүгээр тогтоол, АББҮХ-ны 2014 оны 2 дугаар сарын 5-ны 01 дүгээр тогтоолын 3 дахь заалт |
| 7 | Түлш борлуулах хэсгийн ахлагч нарын цалин, гэрээт борлуулагчдын урамшуулал /2014-2015 онуудад/ - татаас | | НЗДТГ | 356.1 | 356.1 | Эм Жи Эл Эс Би Ди ХХК түлш борлуулсан борлуулагчдын урамшуулал болон тогтмол цалингийн зардлаар 28.6 сая төгрөг тооцогдсон. НАЧА-наас Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсийн хороодын хэсгийн ахлагч нарт 2014 оны 7-р сарын 1 хүртэл урамшууллыг олгохоор тооцсон **327.5** сая төгрөг болно. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Гэр цэгүүдийн борлуулалттай холбогдон гарах зардал /2014-2015 онуудад/ - татаас ( Хас банк) | | НЗДТГ | 299.5 | 299.5 | Урьд онуудын гэр цэгүүдтэй холбогдон гарах зардлыг ММСС санхүүжүүлж байсан болно.2013 оноос Хас банктай гэрээ байгуулсан 2014 оны 5 сарын 31 нд гэрээ дуусна | БОНХЯ-ны сайдын 2013 оны 6 сарын 19-ний өдрийн А-185 дугаар тушаалаар |
| 9 | Агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, сурталчлах | | АББҮХ | 500.0 | 500.0 | Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдалтын багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн ААН, байгууллагад урамшуулал олгох | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $12^1$-р зүйлийн $12^1.2.5$ дахь заалт, МУ-ын Засгийн газрын 2011 оны 11-р сарын 2-ны өдрийн 309-р тогтоолын 3 дахь заалт |
| 10 | Олон нийтэд сургалт сурталчилгаа хийх, нийслэлийн агаарын бохирдлын хэмжээ, урьдчилсан төлөв мэдээг өдөр тутам нийтэд мэдээлэх, сурталчлах, асуудал дэвшүүлсэн мэдээлэл гаргах | 83.0 | АББҮХ, БОНХЯ | 600.0 | 683.0 | Цэвэр агаарын сан хэвлэл мэдээллийн 22 байгууллагатай 2014 он дамнан байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 82.98 сая төгрөгийн үлдэгдэлтэй | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $12^1$-р зүйлийн $12^1.2.7$ дахь заалт |
| 11 | УБ хотын захын хорооллын нам даралтын зуухнуудыг шинэчлэх | | НЗДТГ | 1390.0 | 1390.0 | Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр 2013 онд 2300.0 сая төгрөг төлөвлөж байсан боловч төсвийн тодотголоор 910.0 сая төгрөг болж 2014 онд хэрэгжүүлэхээр болсон | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $12^1$-р зүйлийн $12^1.2.6$ дахь заалт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | УБ хотын захын хорооллын нам даралтын зуухнуудыг татан буулгаж, төвлөрсөн дулаанд холбох /БХЯ/ | 139.0 | БХЯ | | 139.0 | 2013 оны төсвөөс 2322.4 сая төгрөгийг төсөвлөснөөс 1827.4 төгрөгөөр санхүүжүүлж Жаргалконстракшн ХХК-тай байгуулсан УЗ-2013/001 гэрээтэй ажлын хэмжээ хэтэрсэн боловч гэрээний дүнгээр гүйцэтгэлийг тооцож санхүүжүүлсэн, УЗ-2013/003 гэрээний ажлын хэмжээ багасч гэрээнд өөрчлөлт орж гэрээний дүн 207.7 сая төгрөг болж буурсан гүйцэтгэлээр тооцож 356.3 сая төгрөг хасч 139.0 сая төгрөг төлөх тооцоог 2014 онд санхүүжүүлэхээр оруулсан болно. | БОНХЯ-ны сайдын 2013 оны 6 сарын 19-ний өдрийн А-185 дугаар тушаалаар анх төсөв нь батлагдаж, 2013 оны А-360-р тушаалаар шинэчлэгдэн батлагдсан |
| 13 | Агаарын бохирдлын хувь хэмжээг тодорхойлох ухаалаг хяналт | | АББҮХ-ны ажлын алба | 340.0 | 340.0 | | |
| 14 | Сайжруулсан зуухны хяналт тооллого | | АББҮХ-ны ажлын алба, НЗДТГ | 370.0 | 370.0 | | |
| 15 | Автотээврийн хэрэгслээс гарах агаарын бохирдлыг бууруулах, шинэ технологи нэвтрүүлэх, ТҮ сурталчилгаа, утаа хэмжих багаж хэрэгслэл нийлүүлэх, агаар дахь бохирдуулах бодис, хүнд метал тодорхойлох, стандарт нутагшуулах | 38.6 | БОНХЯ, ЗТЯам | | 38.6 | 2013 онд анх 1500.0 сая төгрөг төсөвлөж байсныг төсвийн тодотголоор бууруулж 459.7 сая төгрөг болгож зөрүү **1007.4** сая төгрөгийг 2014 оны төсөл хөтөлбөр луу шилжүүлсэн. 2013 онд хэрэгжсэн гэрээт ажлуудаас ШУТИС-ийн механик инженерийн сургууль, Ягаан сувд ХХК-тай гэрээ байгуулж урьдчилгаа олгогдсон үлдэгдэл 38.6 сая төгрөг нь 2014 оны эхний улиралд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулагдсан. Үргэлжлэн хэрэгжих ажил тул 2014 оны төсөвт суулгаж өгсөн. | Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2012 оны 10-р сарын 2-ны өдрийн хуралдаанаар батлагдсан 12/22 тогтоол, ХЗСайд, ЗТСайд, БОНХСайдын 2013 оны 4-р сарын 2-ны А/70/83/А-104-р хамтарсан тушаалын биелэлтийг шуурхай хангах |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Агаар дахь бохирдуулах бодис, хүнд метал тодорхойлох багаж, дагалдах хэрэгслийн хамт /3ширхэг/ | | ЦУОШГ | 415.6 | 415.6 | 2013 оны төсвийн тодотголоор 2014 онд хэрэгжүүлэхээр 415,6 сая төгрөгийг шилжүүлсэн Түшиг цамхаг ХХК-тай 2013 онд байгуулсан гэрээгээр Цаг уур орчны шинжилгээний газарт байгаль орчны хяналт шинжилгээний лабораторид 3 нэр төрлийн 8 иж бүрдэл багаж, тоног төхөөрөмж, 22 нэр төрлийн урвалж материалыг хүлээлгэн өгсөн.Германаас мэргэжилтэн ирж сургалт явуулсан. | |
| 17 | Автотээврийн хэрэгсэлээс ялгарах хорт хий, утааны тортогжилтын хэмжээг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах | Хаах саналтай | БОНХЯ | 0.0 | | Хаштехник ХХК-тай авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтыг бууруулах төхөөрөмж нийлүүлэх суурилуулах ажлын 830.0 сая төгрөгийн гэрээ байгуулан 747.0 сая төгрөгийг санхүүжүүлэн 83.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Ажлын явц хангалтгүй 66 %-тай, 2013 оны 10-р сарын 31-нд гэрээний хугацаа дууссан. Үндэсний аудитын газрын нийцлийн аудитаар шалгагдсан, аудитын эцсийн дүгнэлтээс хамааран үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Цэвэр агаарын сангийн зүгээс уг төслийг хааж цаашид санхүүжүүлэхгүй гэсэн саналтай байна. | БОАЖ-ын сайдын 2012 оны 4 сарын 16-ны А/132 тоот тушаалаар анх төсөв нь батлагдсан, БОНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 3-р сарын 26-ны А-52 тоот тушаалаар гэрээ байгуулах эрхийг Хаштехник ХХК-нд олгосон |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | Ахуйн хэрэглээнд шатдаг хий ашиглах, аюулгүй хэрэглэх талаар мэдлэг олгох, сэрэмжлүүлэг сургалт зохион байгуулах | Хаах саналтай | ЦАС | 0.0 | | Цогтконсалтинг ХХК-тай 2013 онд 169.9 сая төгрөгийн гэрээ байгуулж 50 хувийн санхүүжилт олгогдсон. Гэрээгээр 84.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Цэвэр агаарын сангаас ажлын гүйцэтгэл хангалттай биш байгаа учраас гүйцэтгэсэн ажлын тайланг хянаж дуусгавар болгон цаашид санхүүжүүлэхгүй хаах саналтай байна. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $12^{1}$-р зүйлийн $12^{1}.2.7$ дахь заалт |
| 19 | Шинэ техник, технологи, инновацийг турших, дүгнэлт гаргах, судалгаа шинжилгээ, мэргэжлийн зөвлөх баг ажиллуулах | | АББҮХ, БОНХЯ | 450.0 | 450.0 | | АББҮХ-ны 2014 оны 02-р тогтоолын 4 дэх заалт |
| 20 | Улаанбаатар хотын агаар бохирдлыг бууруулахад нөлөөллийн үнэлгээ ба прогнозчлолын математик загварчлал | | БОНХЯ | 30.0 | 30.0 | ОХУ-ын ШУ-ны академийн Сибирийн салбарын Эрхүү хот дахь Динамик систем ба удирдлагын хүрээлэн энэ төслийн 60 хувийн санхүүжүүлтийг хариуцаж байгаа, монголын талын 40 хувийн санхүүжилт буюу 30.0 сая төгрөгийн санхүүжилтэнд дэмжлэг авах тухай МУИС-н Математикийн хүрээлэнгээс 2013/10/3-ны 40/13 тоот албан бичгээр хүсэлт тавьсан. | |
| 21 | Хот суурин газрын агаарын бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа хийх зөвлөх үйлчилгээ | 27.7 | БОНХЯ | | 27.7 | 2014 оны 4 сарын 30-нд судалгааны ажлын эцсийн тайлан өгнө. 2014 оны 2-р сарын 6-нд Нобелийн шагналт эрдэмтэн Кэрк Смитээр ахлуулсан баг ирж судалгааны ажлын үр дүнгийн мэдээлэл өгсөн. | БОАЖЯ-ны сайдын 2012 оны 4 дүгээр сарын 16-ны А-132 дугаар тушаалыг үндэслэн |
| 22 | Дотоод зардал | | ЦАС | 330.0 | 330.0 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Нийслэлийн нийтийн тээврийн их багтаамжийн автобусыг дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах | Хаах саналтай | ЗТЯ | | | 2011 оны төсөвт тусгагдаад хэрэгжиж буй ажил удаашралтай байгаа. Туртелком ХХК-тай 2013 оны 3 сарын 28-нд байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэлээр хүлээгдэж буй гүйцэтгэл **338.0** сая төгрөг байгаа. Үндэсний аудитын газрын нийцлийн аудитаар шалгагдсан, аудитын дүгнэлтээс шалтгаалан санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. | АББҮХ-ны 2011 оны 11/05 дугаар тогтоолын 1 дэх заалт, 2012 оны 12/16 дугаар тогтоолын 4 дэх заалт |
| 24 | Цагаан даваа орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, Цагдаагийн академи, УС-15 орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох | 70.1 | НЗДТГ | | 70.1 | НАБСАН ХХК 2011 онд Цагаан даваа орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаанд холбох 2299.8 сая төгрөгийн, 2012 онд Цагдаагийн академи Ус 15 орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох 3144,0 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн гүйцэтгэлээр олгох **70.1** сая төгрөг үлдэгдэлтэй байгаа | ЦАС-гийн УЗ-ийн 2011 оны 3-р сарын 31 болон 4-р сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэр, 2011 оны 8-р сарын 5-ны өдрийн 05/01 тоот тогтоолыг тус тус үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2012 оны 4 дугаар сарын 16-ны А-132 дугаар тушаалыг үндэслэн |
| 25 | Автомашин хийгээр цэнэглэх зөөврийн станц байгуулах | 12.9 | БОНХЯ | | 12.9 | Дашваанжил ХХК суурин 4 станцыг 2013 онд улсын комисст хүлээлгэн өгсөн.( БГД 20-р хороо Драгоны эсрэг тал, БЗД 12-р хороо, Ботаникийн замын хойно, БЗД 4-р хороо Их засаг сургуулиас зүүн тийш 300м, СХД 4-р хороо Их наран толгойт явах замын урд) Зөөврийн 4 станцыг хүлээлгэж өгөөгүйгээс **12.9** сая гүйцэтгэл хүлээгдэж байгаа | УИХ-ын 2010 оны 6-р сарын 25-ны өдрийн 36 тоот тогтоолын 4.4.5.16 дахь заалтын дагуу ЦАС-гийн УЗ-ийн 2011 оны 3-р сарын 31 болон 4-р сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэр, 2011 оны 8-р сарын 5-ны өдрийн 05/01 тоот тогтоолыг тус тус үндэслэн |
| | **Нийт дүн** | **3972.9** | | **16287.9** | **20260.8** | | |

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2014 оны 03 дугаар сарын 17 ны өдрийн
А-93 тоот тушаалын 2 дугаар хавсралт

**Цэвэр агаарын сангийн 2014 оны дотоод зардлын төсвийн төлөвлөгөө**

/сая.төгрөгөөр/

| д.д | Төсвийн зарлага | 2013 оны гүйцэтгэл | 2014 оны төсвийн төлөвлөгөө | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | | **192.6** | **330.0** | **137.4** |
| | **II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **192.6** | **330.0** | **137.4** |
| | **IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **192.6** | **330.0** | **137.4** |
| | **Бараа, үйлчилгээний зардал** | **192.3** | **327.0** | **134.7** |
| | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **89.8** | **189.9** | **100.2** |
| 1 | Үндсэн цалин | 67.0 | 61.9 | 81.9 |
| 2 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 8.3 | 22.2 |
| 3 | Гэрээт ажилчдын цалин | 11.3 | 100.9 | -11.3 |
| 4 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11.5 | 18.8 | 7.3 |
| | **Бараа, үйлчилгээний бусад зардал** | **102.6** | **137.1** | **34.5** |
| 5 | Бичиг хэрэг | 7.6 | 8.0 | 0.4 |
| 6 | Тээвэр (шатахуун) | 10.1 | 10.0 | -0.1 |
| 7 | Шуудан, холбоо | 2.6 | 7.1 | 4.5 |
| 8 | Дотоод албан томилолт | 0.6 | 1.4 | 0.8 |
| 9 | Гадаад томилолт (арга хэмжээ) | 28.4 | 29.4 | 1.1 |
| 10 | Ном, хэвлэл авах | 0.7 | 0.7 | 0.0 |
| | **Эд хогшил худалдан авах** | **15.4** | **10.0** | **-5.4** |
| 11 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 2.3 | 2.5 | 0.2 |
| 12 | Эд хогшил худалдан авах зардал | 13.1 | 7.5 | -5.6 |
| 13 | Урсгал засварын зардал | 9.2 | 10.0 | 0.8 |
| 14 | Төлбөр хураамж болон бусад зардал | 14.6 | 14.6 | 0.1 |
| 15 | Гадаад зочны зардал | 0.1 | 1.0 | 0.9 |
| 16 | Байрны түрээсийн хөлс | 5.9 | 27.3 | 25.4 |
| 17 | Мэдээлэл, зар сурталчилгаа | 1.2 | 1.5 | 0.3 |
| | **Сургалт, хурал, зөвлөгөөний зардал** | **5.7** | **10.0** | **0.3** |
| 18 | Сургалт семинар зохион байгуулах зардал, | 5.7 | 10.0 | 0.3 |
| | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж** | **0.6** | **6.0** | **5.4** |
| 19 | ТӨГАҮ Ажил олгогчийн урамшуулал | 0.6 | 6.0 | 5.4 |
| | **Татаас ба урсгал шилжүүлэг** | **0.3** | **3.0** | **2.7** |